



“МИК ХОЛДИНГ” ХК

## ТӨЛӨӨЛӨН УДИРАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 3 сарын 17 өдөр

№ 23/08

Улаанбаатар хот

### Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4 дэх хэсэг, 64 дүгээр зүйлийн 64.2 дахь хэсэг, 65 дугаар зүйлийн 65.1, 65.4 дэх хэсэг, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3, 71.4 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 377 тоот тогтоолоор батлагдаж 2021 оны 45 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан “Хувьцаа компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.7.11, 9.7.12 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2016 оны 16/22 дугаар тогтоолоор батлагдаж 2021 оны 21/08 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан “Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулах тухай журам”-ыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ**:

1. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 11:00 цагт компанийн боловсруулсан мэдээллийн технологи, программ хангамжийг ашиглан цахим хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлэхээр шийдвэрлэсүгэй. Үүнд:
  1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлт;
  2. Ногдол ашиг хуваарилах эсэх талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэр;
  3. ТУЗ-ийн 2022 оны үйл ажиллагааны тайлан;
  4. Компанийн дүрмийн нэмэлт өөрчлөлт;
  5. ТУЗ-ийн гишүүдийн цалингийн зардлын төсөв.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2023 оны 4 дүгээр сарын 10-ны өдрөөр тогтоосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Комиссын дарга:	Г.Саруул,	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга;
Гишүүн:	Х.Маралмаа,	ТУЗ-ийн ажлын албаны хуульч.

5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын мэдэгдлийг 2023 оны 3 дугаар сарын 20-ны өдөр Санхүүгийн Зохицуулах Хороо болон “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-д тус тус хүргүүлэхийг хурал зохион байгуулах комисс (Г.Саруул)-т даалгасугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай зарыг Хавсралт 1-р баталж, 2023 оны 3 дугаар сарын 22-ны өдөр болон мөн оны 4 дүгээр сарын 07-ны өдөр тус тус хоёроос доошгүй өдөр тутмын сонин, компанийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлэхийг Хурал зохион байгуулах комисс (Г.Саруул)-т даалгасугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг Хавсралт 2-р баталж, энэхүү баримт бичгийг 2023 оны 3 дугаар сарын 27-ны өдөрт багтаан хувьцаа эзэмшигчдэд тэдгээрийн бүртгэлтэй үнэт цаасны компаниудаар дамжуулан хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлж, танилцах бололцоогоор хангаж ажиллахыг Хурал зохион байгуулах комисс (Г.Саруул)-т даалгасугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын үүргийг орлон гүйцэтгэгч (Ч.Хашчулуун) -г томилсугай.

9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:
- Комиссын дарга: М.Батбаяр, "МИК ОССК" ХХК-ийн Санхүү, удирдлагын газрын Актив, пассив удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн;
- Гишүүн: Б.Болортuya, "МИК ОССК" ХХК-ийн Хянан нийцүүлэлтийн газрын захирал;
- Гишүүн: Н.Эрдэнэчимэг, "МИК ОССК" ХХК-ийн Санхүү, удирдлагын газрын Төлбөр тооцооны хэлтсийн захирал.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах шийдвэрийн төсөлд хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар санал авч, түүнийг үндэслэн хурлын тогтоолыг гаргахыг хурлын дарга (Ч.Хашчуулун)-д даалгасугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг Хавсралт 3-р, санал хураалтаар шийдвэрлэх асуудал бүрээр "Санал авах хуудас"-ны загварыг Хавсралт 4, 5, 6 -р тус тус баталсугай.
12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудсыг хувьцаа эзэмшигчдэд тэдгээрийн бүртгэлтэй үнэт цаасны компаниудаар дамжуулан хүргүүлэхийг Хурал зохион байгуулах комисс (Г.Саруул)-т, хурлаар шийдвэрлэх асуудалд өгсөн саналыг хурлын мэдэгдэл гаргасан өдрөөс эхлэн 2023 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 17:00 цаг хүртэл хүлээн авах, түүнтэй холбоотой бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Тооллогын комисст тус тус үүрэг болгосугай.
13. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулахтай холбоотой зардлыг санхүүжүүлэхийг Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-д даалгасугай.
14. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хороо (Ч.Хашчуулуу)-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН  
ҮҮРГИЙГ ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

  
Ч.ХАШЧУУЛУУН

